



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/280

Мөрөн сум

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал,  
эрүүл ахуйн салбар зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1.7, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2015 оны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого үйл ажиллагааг зохион

байгуулах ахлах мэргэжилтэн

Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

“Хөвсгөл зам” ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

асуудал хариуцсан ажилтан

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл, “Малчин таны төлөө”

хоршооны тэргүүн

Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл, “Ундарга тек” ХХК-ийн захирал

Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл, Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн

харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/49 зүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712010868